



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2018 оны 4 дүгээр
сарын 17-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. “Монголын эдийн засгийн чуулган-2018” арга хэмжээг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Дарга	-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Орлогч дарга	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Гишүүд:	-Гадаад харилцааны сайд; -Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд; -Эрүүл мэндийн дэд сайд; -Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын асуудал хариуцсан зөвлөх; -Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

- Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Үндэсний хөгжлийн газрын дарга;
- Татварын ерөнхий газрын дэд дарга;
- Нийслэлийн Засаг даргын дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч;
- Монголбанкны судалгаа, статистикийн газрын захирал (тохиролцсоноор);
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;
- “СЕО” клубын ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- “СЕО” клубын гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- Гүйцэтгэх захирлуудын клубын зохицуулагч (тохиролцсоноор);
- “Дефакто институт”-ийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга /тохиролцсоноор/;
- Монголын банкны холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Бодлого, үйл ажиллагааны хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Эдийн засаг бүтээн байгуулалт хариуцсан ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (тохиролцсоноор);
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн бодлогын зөвлөлийн ажлын албаны хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан дэд дарга.

Нарийн бичгийн
дарга

2. Эдийн засгийн чуулганаар хэлэлцэх асуудал, тавих илтгэлийн сэдвийг оновчтой сонгож, хурал зохион байгуулах зардлын тооцоог гаргах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх талаар санал боловсруулж чуулганы бэлтгэлийг хангах, чуулга уулзалтад төв, орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуй нэгж, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах ажлыг зохион байгуулан, ажлын явцыг тухай бүр Засгийн газарт танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Занданшатар)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 39 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ